



04

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 12 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 495

Улаанбаатар
хот

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар
авах зарим арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 10.1.7, 43.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:

1.1. Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийг бүрэн олгох боломжгүй нөхцөл байдал үүссэн бол нэн шаардлагатай зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн санхүүжилтийн үлдэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;

1.2. барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөрт багтаан бодит гүйцэтгэлийг хянан санхүүжүүлэх.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд үүрэг болгосугай.



Монгол Улсын Ерөнхий сайд

Сангийн сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН